



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/15/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өмнөговь аймаг  
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: [tserenbayars@audit.gov.mn](mailto:tserenbayars@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: [khongorzult@audit.gov.mn](mailto:khongorzult@audit.gov.mn)

Аудитор: Н.Хулан

Утас: 70533552 Цахим хаяг: [khulann@audit.gov.mn](mailto:khulann@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



г. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь “Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэн бэхжүүлэх, сумын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн идэвхтэй оролцоо, хяналтад тулгуурлан шийдвэрлэх асуудал юм.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

**Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд**

		/төгрөгөөр/
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
	<b>Үзүүлэлт</b>	<b>2021.12.31</b>
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<b>310,000.00</b>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<b>1,763,999.80</b>
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b><u>2,073,999.80</u></b>
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b><u>2,073,999.80</u></b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
	Үйл ажиллагааны орлогын дүн	<b>70,179,600.00</b>
	Үйл ажиллагааны зардлын дүн	<b>69,683,100.15</b>
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>496,499.85</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>496,499.85</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,577,499.95</b>
	Тайлант оны үр дүн	<b>496,499.85</b>
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,073,999.80</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<b>68,479,600.00</b>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<b>68,479,600.00</b>
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	67,814,200.00
	Урсгал зардал	67,814,200.00
	Хөрөнгийн зардал	
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	67,814,200.00
	Улсын төсвөөс санхүүжих	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,814,200.00

**Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	-----------------------------	--------------------------	-------------------------



A	1	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
1	ТШЗ	1	1				1		
2	ТТЗ								
3									
<b>НИЙТ</b>									

### Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5.1 сая төгрөгийн гүйлгээ, 0.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.4 “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*”, 6.4.5 “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*”, заалтыг тус тус хэрэгжүүлээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

### Тав. Аудитын үр дүн

#### 5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	10.2					2	10.2		
2	ТТЗ										
<b>НИЙТ</b>											

**5.2 Аудитын илрүүлэлт:** /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 10.2 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

**Зургаа. Аудитын санал дүгнэлт** /баталгаажсан хувийг оруулах/



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Ц.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

2022.02.22 № 129

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцэст 1,763,999.8 төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1,299,000.0 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам" УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

016000041



Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР .

С.ЦЭРЭНБАЯР